

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл
10	10.1. Хяналт шалгалт, үнэлгээ	10.1.1. “Стратеги төлөвлөгөө-2050”, “Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр-2050”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, дунд хугацааны зорилтуудын хэрэгжилтийг хангах.	<p>2021-2024 онд гүйцэтгэх, тэргүүлэх чиглэлийн нэг дүгээрт “Тавантолгой -Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын 240 км төмөр замыг ашиглалтад оруулахын тулд:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Төмөр замын цогц бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх,</li> <li>▪ Суурь бүтцийг барих үйл ажиллагааны менежментэд захиалагчийн хяналт тавих,</li> <li>▪ Суурь бүтцийг хүлээн авч, тээвэрлэлтийн үйл ажиллагааг зүгшрүүлэх,</li> <li>▪ Хөдлөх бүрэлдэхүүн худалдан авах, зүгшрүүлэх үйл ажиллагааг хангах,</li> </ul> <p>Энэ бүхний дүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Тээвэр, логистикийг түшиглэсэн төмөр замын цогц үйлчилгээг хэрэгжүүлэх бодлого хэрэгжиж, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулж, оновчтой зөв зохион байгуулах,</li> <li>▪ Дүрэм, журам, гэрээ болон тээвэр логистик, шилжүүлэн ачих терминал, нүүрс ачих логистик, түр ачилтын талбай, тээврийн бэлтгэлийг хангах, ачаа тээвэр зуучлалын гэрчилгээ, өртөө зөрлөгийн код дугаар авах, тарифийн жишгийг боловсруулах 167 ажлын хэрэгжилт 87.50 хувьтай байна,</li> <li>▪ Суурь бүтэц ашиглалтын тариф, тээвэрлэлтийн тариф, нэмэлт ажил үйлчилгээний тариф болон тарифын 1, 2 дугаар мөрдлөгийг боловсруулж батлуулсан,</li> <li>▪ Олон улсын төмөр замуудын холбоонд хүсэлт гаргаж, 2022.06.20-ны өдөр байгууллагын 5083 кодыг албан ёсны болгож, баталгаажуулж авсан,</li> </ul>
	10.1.2. Сангийн яам, Үндэсний аудитын газрын шалгалтын үр дүнгээр өгсөн зөвлөмж, шаардлагуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	<ul style="list-style-type: none"> <li>▪ Санхүүгийн өдөр тутмын ажил үйлчилгээний төлбөр, гүйлгээг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, СТОУС-ын дагуу хөтлөх, санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын тайланг тайлагнах,</li> <li>▪ Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, бусад холбогдох тайланг хуулийн хугацаанд гаргах,</li> <li>▪ Үндэсний аудитын газраас ирүүлсэн зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийг төлөвлөгөө гарган батлуулж холбогдох байгууллагад хүргүүлэн хэрэгжилтийг хангах, жилийн эцсийн тайланг аудитаар баталгаажуулж, <b>стандарт дүгнэлт</b> авсан,</li> <li>▪ Хэрэгжиж буй төсөл тус бүрээр дансны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, бүртгэлийн системд өөрчлөлт хийж, төсөл тус бүрд санхүүгийн бааз, толгой болон охин компанийн зарчмаар санхүүгийн тайланг тус бүрд нь гаргаж, санхүүгийн нэгдсэн тайлан мэдээг боловсруулах, санхүүгийн программд хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж ирсэн байна.</li> </ul>	

		<p>10.1.3. Төлөвлөгөөт хугацааны санхүү, бүртгэлийн үйл ажиллагаагаа хянан баталгаажуулах, дотоод аудитыг хэрэгжүүлэх.</p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Анхан шатны бүртгэлийн маягыг болон I-III улирлын санхүү, төлөвлөлтийг архивлах,</li> <li>▪ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдүүлэлт,</li> <li>▪ Гадаад албан томилолтын байдал,</li> <li>▪ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг болон цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлэх, шийдвэрийн хуулбаруудыг оруулсан буюу мэдээллийг хугацаа хоцроосон эсэх,</li> <li>▪ Хангамжийн үйл ажиллагаатай холбогдох баримт, иж бүрдэлд шалгалт хийсэн,</li> <li>▪ Худалдан авалтын хууль тогтоомжийн хэрэгжилтэд болон хөдөлмөр хамгааллын зуны гутлын чанар зэрэгт дүгнэлт хүргүүлсэн болно.</li> </ul>
		<p>10.1.4. Компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй зорилтот хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг хангуулах.</p>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Төмөр замын бүтээн байгуулалтыг шуурхай зохион байгуулж, суурь бүтцийн барилгын ажлыг дуусган техникийн комисст хүлээлгэж өгсөн.</li> <li>▪ Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын ажлыг бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулж, оновчтой зөв зохион байгуулж ирсэн.</li> <li>▪ Хөдөлгөөн, зохион байгуулалтад хөтөлгөх 5 төрлийн 5000 ширхэг маягт, 3 төрлийн 300 ширхэг зурмаг, 14 төрлийн 380 ширхэг дэвтэр, ачаа тээвэрлэлтийн өдөр тутмын үйл ажиллагаа, орлого бүрдүүлэлтэд хяналт тавих ажлын дэвтэр хөтлөлт, загваруудыг хэвлүүлж, үйл ажиллагааны 11 заавар, технологийн горим ба карт, гэрээг боловсруулж ажилласан.</li> <li>▪ Суурь бүтэц ашиглалтын тариф, тээвэрлэлтийн тариф, нэмэлт ажил үйлчилгээний тариф болон тарифын 1, 2 дугаар мөрдлөгийг боловсруулж, батлуулсан.</li> <li>▪ "ГТХЗНТ" УТҮГ-ын зөвлөмжид тулгуурлан ОУТЗХ-нд хүсэлт гаргаж (2022.06.20), байгууллагын 5083 кодыг албан ёсны болгон баталгаажуулсан.</li> <li>▪ ЗАА-д мөрдөх 12 журам, 2 технологийн горим, 1 авто тормосын зааврыг боловсруулж, мөн 11 журам, 1 зааврыг хуулийн шатанд хэлэлцэж, холбогдох байгууллагад хүргүүлж, батлуулсан.</li> <li>▪ Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ гүйцэтгэх зөвшөөрөл авах, хөдлөх бүрэлдэхүүнд гэрчилгээ шинээр авах ажлыг зохион байгуулсан.</li> <li>▪ Гэрээ (ЕРС)-нд заасан вагон засварын депод угсрагдах 139 тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг хянан баталгаажуулж, багаж болон бусад хэсэгт орсон 92 нэр төрлийн 936 ширхэг багаж, 147 нэр төрлийн 404 ширхэг хэмжих хэрэгслийг /ТГНУ 289172 дугаартай чингэлэг/-ийг хүлээн авч, бүртгэлжүүлсэн.</li> <li>▪ Ерөнхий гүйцэтгэгчтэй хийсэн ажил гүйцэтгэх ЕРС гэрээний хүрээнд 810 ширхэг ачааны вагоныг хүлээн авахаас 100 хагас вагон /12-9853/-ыг, 7 дугаар сард 100 тавцанд вагон /13-6724/-ыг, 10 дугаар сард 200 тавцанд вагон, нийт 400 вагон хүлээн авсан.</li> </ul>

			<p>“ТНАЛТ” төслийн хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /2021.05.17/-ийн 20 дугаар тогтоолд заасны дагуу уг төслийн техник эдийн засгийн үндэслэл, зураг, төслийг боловсруулах, хянан баталгаажуулах, магадлуулах, барилгын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах, хүлээлгэн өгөх ажлыг “Тавантолгой төмөр зам” ХХК-д даалгасныг хүлээн авсан,</li> <li>2. Компанийн ТУЗ-ийн 04-р тогтоолоор зураг, төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээг гүйцэтгэгч компанитай байгуулахыг манайд зөвшөөрсөн,</li> <li>3. ТЭЗҮ-ийг боловсруулан магадлуулж, бэлтгэл ажлыг эхлүүлэн гэрээ, хэлэлцээрийн хүрээнд төслийн 6 багц ажлыг 28 сарын хугацаанд бүрэн гүйцэтгүүлэх төлөвлөгөө гаргаж, 12-р сарын байдлаар 25,2 хувийн биелэлттэй байна.</li> </ol> <p>“Богдхан” төмөр замын төслийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ ТЭЗҮ-ийг ШУТЗ-өөр хэлэлцүүлэн магадлуулж, доод бүтцийг ЗХЖШ, дээд бүтцийг “Улаанбаатар төмөр зам” ХНН болон эстакадан гүүр, туннелийн барилга угсралтыг “Бодь интернэшнл” ХХК гүйцэтгэх шийдвэрт хүрч, Захиалагчийн зүгээс гэрээ, хэлэлцээр байгуулсан.</li> <li>▪ Хэлэлцээрээр уг төслийн төсөвт өртөгийг 1,404.8 сая.доллараар баталсан.</li> <li>▪ “ЭТТ” ХК-ийн ТУЗ-ийн 28-р тогтоолд “Гэрээ байгуулах эрх олгох тухай”, манай компанийн ТУЗ-ийн 12 дугаар тогтоолд “Гэрээ байгуулах тухай”, 31 дүгээр тогтоолд заасан санхүүжилтээр “Богдхан төмөр зам”-ын эстакадан гүүр, туннелийн барилга байгууламжийн зураг, төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-г гүйцэтгэгч компанитай байгуулах эрхийг манайд олгосон.</li> </ul> <p>Гүйцэтгэх захирлын батласан “А”, “Б” тушаал шийдвэрийн хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Журам, заавар, жагсаалт болон тарифтай холбоотой 53 тушаал буюу 76 хувь, хэрэгжиж эхлээгүй 3 журам буюу 4 хувь, бүрэн хэрэгжсэн 6 тушаал буюу 8.5 хувь, тушаалын хэрэгжилт үргэлжилж байгаа 10 буюу 14%; түр хугацаагаар хойшлогдсон 1 тушаал тус тус байна.</li> <li>• Үргэлжилж буй 7 тушаал байгаагаас хэрэгжилт ирүүлээгүй 1 буюу 6 ажлын хэсгийн тушаал байна.</li> <li>• 2022.03.31., “Б” 45 тушаал нь 2021 оны А/19 тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг үндэслэн шийдвэрлэсэн байна.</li> <li>• “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баримтлан хөдөлмөрийн дотоод журамд зарим өөрчлөлтийг А/26 тушаалаар баталж, тушаал шийдвэрүүд уг журмаар албажин явж байна.</li> </ul>
--	--	--	--

			<ul style="list-style-type: none"><li>• “Б” тушаал 676 гарснаас 62,7 хувь буюу 424 тушаал ажилтанг <i>туршилтын хузаацаагаар ажиллуулах тухай</i> байна.</li><li>• “Богдхан төмөр зам” төслийн кемп үйлчилгээний ажлын хэсэг шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний захиалгыг Гүйцэтгэх захиралд хүргүүлж, ажилласан байна.</li><li>• Оффисын ажилтнуудын 2022 оны эхний хагас жилийн цагийн бүртгэл, ирцэд үзлэг шалгалт хийж, дүнг ЗУГ-т хүргүүлсэн.</li><li>• Инженер, тцхинийкийн ажилтнуудын ажиллах өртөө, зэрлөг, ажлын байрны нөхцөлтэй холбогдуулан гаргасан А/50 тушаалын гүйцэтгэлд хяналт хийж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.</li><li>• Ирсэн, хариу явуулсан албан бичиг хэргийн хөтлөлтөд хяналт шинжилгээ хийж үзэхэд III, IY улирлын байдлаар 1261 ирсэн, явуулсан албан бичиг, 105 өргөдөл, гомдол ирсэн байна.</li></ul>
--	--	--	---